



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 457

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 64,454,344.00 (жаран дөрвөн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга гурван зуун дөчин дөрвөн) төгрөгийн балансын үнэ, 30,078,693.79 (гучин сая далан найман мянга зургаан зуун ерэн гурван төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Мэдээллийн Монцамэ агентлагт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр, Мэдээллийн Монцамэ агентлагийн дарга Б.Ганчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн
457 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, МЭДЭЭЛЛИЙН МОНЦАМЭ АГЕНТЛАГТ БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар | Балансын үнэ (төгрөг) | Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|-----|---|--|---|--|
| 1 | Ланд 105, 01-61 УБЗ, JTECJ095905510917 | 64,454,344.00 | 30,078,693.79 | 34,375,650.21 |
| | | 64,454,344.00 | 30,078,693.79 | 34,375,650.21 |
| | Нийт дүн | (жаран дөрвөн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга гурван зуун дөчин дөрвөн) | (гучин сая далан найман мянга зургаан зуун ерэн гурван төгрөг далан есөн мөнгө) | (гучин дөрвөн сая гурван зуун далан таван мянга зургаан зуун тавин төгрөг хорин нэгэн мөнгө) |